

МОНГОЛЫН ОРОН НУТГИЙН МЭДЭЭ

АЗИЙН БҮСИЙН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗӨВЛӨЛИЙН ЗАХИАС БИЧИГ

Гэр бүлийн харилцааг бэхжүүлэх нь

Гэррит В.Гонг

Далын ахлагч, Азийн бүсийн ерөнхийлөгчийн нэгдүгээр зөвлөх

Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээ нь бидэнд гэр бүл бол энэ цагийн болон үүрд мөнхийн хамгийн чухал нэгж хэмээн заадаг. Гэр бүлийн харилцааг бэхжүүлэхээс илүү чухал, хүч чадал сорьсон сайн үйлс байхгүй.

Сайн мэдээгээр амьдрах нь биднийг өсч хөгжихөд тусалдаг. Итгэл, ойлголт, сайхан сэтгэл, энэрэл өсөх үед бид хоорондоо дотносож, гэр бүлийн харилцаа илүү утга учиртай болдог. Гэр бүлийн үдэш, долоо хоног бүрийн ариун ёслол, ариун сүмийн хүчинтэй эрхийн бичиг зэрэг нь биднийг Тэнгэрлэг Эцэг болон гэр бүлийн гишүүдтэйгээ харилцах харилцаагаа хүчирхэгжүүлэхэд тусалдаг. Түүнчлэн судрууд, Сүмийг удирдах нь: Гарын авлага 1 болон “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг” зэрэг нь гэр бүлээ энэ үед нэгдмэл, хүчирхэг байлгах мөн мөнх амьдралд үүрдийн гэр бүл болгоход бидэнд туслах зарчмуудыг агуулдаг.

Гэр бүлийн тухай сэргээгдсэн сайн мэдээний үнэнүүд дараах зүйлсийг багтаадаг:

“Гэр бүл нь Бурханаар томилогдсон. Гэр бүл нь энэ цаг үеийн болон үүрд мөнхийн хамгийн чухал нэгж юм.”

Энэ дэлхийд төрөхөөсөө өмнө бид Тэнгэрлэг Эцэг, Эхийн сүнсэн охид хөвгүүд байсан. Бид Тэнгэрлэг Эцэгийн гэр бүлийн нэг хэсэг билээ.

Бид Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний нэг хэсэг нь болж гэр бүлүүдэд мэндэлсэн. Тэнгэрлэг Эцэг биднийг аз жаргалтай байлгаж, хайраар дүүрэн орчинд зөв зарчмуудыг суралцахад туслах гэж мөн биднийг мөнх амьдралд бэлтгэхийн тулд гэр бүлүүдийг бий болгосон юм.

Есүс Христийн Цагаатгал бидэнд сүнслэг болон бие махбодын үхлийг даван туулах боломжийг олгосон. Энэ нь гэр бүлийн харилцаа үхлийн дараа ч үргэлжилнэ гэсэн үг юм. Бид ариун сүмд хийсэн нандин ёслолууд, гэрээнүүддээ үнэнч байх юм бол гэр бүлийнхэнтэйгээ мөнхөд хамт байх боломжтой.

Гэр бүлийн харилцааг бэхжүүлэх үнэн зарчмууд нь дараах зүйлсийг багтаадаг:

Бид өөрсдөө болон гэр бүлийн гишүүдтэйгээ хамт суралцаж хөгжсөнөөрөө гэр бүлийн харилцаагаа бэхжүүлдэг.

Есүс Христийн талаарх гэрчлэлээ гүнзгийрүүлэх үед бид Түүний зарлигуудад дуулгавартай байхыг эрэлхийлж, Түүний адислалуудыг гэр бүлийнхэн болон бусадтайгаа

хуваалцахыг хүсдэг.

Бурханд ойртох үед бидний хувийн сүнслэг байдал өсдөг. Бид залбирч, судраас судлан, тунгаан бодож, дуулгавартай байснаараа сүнслэгээр өсч хөгждөг.

Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан бид нүглээс цэвэршигдэн ариусгагдаж чадна. Аврагчийн Цагаатгал бидэнд гэр бүлийн харилцаагаа бэхжүүлэх чадварыг өгч бас энэхүү хүслээ нэмэгдүүлэхэд ч туслах болно.

Бид гэр бүлийн харилцаагаа зөвхөн итгэл үнэмшил, уйгагүй тэвчээр, даруу дөлгөөн зан,



**Далын Ахлагч
Гэррит В.Гонг**

чин сэтгэлийн хайраар бэхжүүлдэг. Бид гэр бүлийн харилцаагаа сайхан сэтгэлээр, хоёр нүүр мөн ов мэх гаргалгүй, зүрх сэтгэлийг маань тэлэх цэвэр мэдлэгээр бэхжүүлж чадна. Хэрэв бид Ариун сүнсний шивнээг сонсч, гэр бүлийн нэг гишүүнээ засч залруулах хэрэгцээг мэдэрсэн бол дараа нь түүнийг хайрлах хайраа нэмэгдүүлснээ харуулах хэрэгтэй.

Хувь хүмүүс болон гэр бүлүүдийн хувьд хайр, урамшууллыг мэдрэх үедээ илүү хурдан, илүү сайнаар өөрчлөгдөж өсч хөгждөг. Үүнтэй адил бидний гэр бүлийн харилцаа нь бие биедээ хайр, итгэл найдвар, урам зориг өгөх үед илүү хурдан сайжран, хөгждөг байна.

Гэр бүлийн харилцаа нь хүн бүр хайранд нэгдэн, тодорхой нэгэн харилцаа, талархал, тааламжтай байдлыг хүлээн авч, харилцан мэдэрснээр мөн нэгдмэл нэг зорилготойгоор ажиллаж, хуваалцах зэрэг бусад олон арга замуудаар бэхждэг.

Бидний гэр бүлүүд болон гэр бүлийн нөхцөл байдлууд бүгд хоорондоо ялгаатай. Зарим гэр бүлүүд нь ганц бие гэрлээгүй, тусдаа амьдардаг, салсан эсвэл бэлэвсэрсэн хувь хүнээс бүрддэг. Зарим гэр бүлд нөхөр эхнэр хоёр л байдаг бол заримд нь хүүхдүүд бий. Зарим гэр бүлүүд өвөө эмээ, эцэг эх болон хүүхдүүд гэх зэрэг олуулаа байдаг. Зарим нь гэр бүлээрээ сүмийн гишүүн. Зарим гэр бүлүүдэд сүмийн гишүүн хараахан болоогүй хүмүүс ч бий. Сүмийн гишүүн том хүн, хүүхэд эсвэл арай гишүүн болоогүй байгаа нь ялгаагүй, аль ч гэр бүлд бид сайн мэдээний зарчмуудаар амьдарснаар өөрсдийн гэр бүлийн харилцаагаа хөгжүүлж чадна.

Энд би Азийн бүс дэх зарим жишээнүүдээс дурдъя.

Залуу эмэгтэй ба эрэгтэй, ганц бие залуучууд болон эцэг эхчүүд

Манай Азийн бүсэд олон залуу эрэгтэй ба эмэгтэй, ганц бие залуучууд болон ганц бие хүмүүс сүмд нэгдсэн эсвэл сүмд нэгдэхийг хүсдэг.

Одоогоор та бүхний ихэнх нь гэр бүлдээ ганцаараа сүмийн гишүүн байгаа. Янз бүрийн шалтгаанаар та нарын аав эсвэл ээж сүмийн тухай хараахан ойлгоогүй байж магадгүй. Заримдаа та нарын аав эсвэл ээж сүмд явахыг чинь эсэргүүцдэг байх. Магадгүй гэр бүлд сөргөлдөөн, үл ойлголцох явдал ч гарч болно.

Ийм нөхцөл байдалд хүмүүс гэр бүлийн харилцаагаа хэрхэн хөгжүүлсэн хоёр жишээг үзүүлье.

Нэгэн итгэлтэй залуу эрэгтэй сэргээгдсэн сайн мэдээний бат бөх гэрчлэлтэй болсон байна. Тэрээр сүмд нэгдэхийг хүссэн боловч эцэг эх нь эсэргүүцжээ. Тэр Бурханаа хайрлах болон эцэг эхээ хүндэтгэх зарлигийг хоёуланг нь дуулгавартай дагахыг эрэлхийлжээ. Тэрээр эдгээр зарлигийг хэрхэн хамтад нь дагаж болдгийг би сурсан юм гэжээ. Өглөө бүр тэр эцэг эхтэйгээ “өглөөний мэнд, аав аа” “өглөөний мэнд, ээж ээ” хэмээн эелдгээр мэндэлдэг байв. Тэр шаргуу ажиллаж бас хичээлдээ ч сайн байв. Тэрээр гэр доторх үүрэг хариуцлагаа гүйцэтгэхдээ дуулгавартай мөн баяр хөөртэй байлаа. Эцэг эх нь түүнд гарсан эерэг өөрчлөлтийг харж, хүүгээ сүмд нэгдэхийг зөвшөөрчээ. Тэд түүнийг итгэлдээ үнэнч мөн зохистой байгаасай хэмээн хүсэн юм. Тэрээр ийм байж чадсан.

Нэгэн залуу эмэгтэй гэр бүлээсээ ганцаараа сүмд нэгджээ. Түүнийг анх сайн мэдээг суралцаж сүмд нэгдэхийг хүсэхэд аав нь зөвшөөрөл өгөхгүй байв. Тэрээр баптисм хүртэх боломжийг олон сар хүлээсэн юм. Гэхдээ тэр Их Эзэн болон эцэг эхээ дээдлэн хүндэтгэдэг байлаа. Түүнээс хойш бусад гэр бүлийн гишүүд нь түүнтэй хамт сүмд нэгдсэн. Олон жилийн турш итгэлтэй байсан тэрээр одоо элэнц эмээ болоод байна. Тэр итгэлдээ бүхнээ зориулсан бөгөөд итгэлийнх нь учир хүүхдүүд, ач, гуч нар нь бүгд гэрээнд төрцгөөжээ.

Сая миний ярьсан залуу эмэгтэй бол миний ээж гэдгийг та нар таамагласан байж магад. Ээж минь гэр бүл болон хамаатан садантайгаа олон жилийн турш сайхан харилцааг

итгэлтэйгээр бий болгож өгсөнд бид мөнхөд талархалтай байдаг.

Эдгээр жишээнүүд нь арван зарлигийн нэг болон тав дахь зарлигтай юугаараа нийтлэг холбоотой байна вэ? Нэг дэх зарлиг нь бидний дуулгавартай байдал болон Тэнгэрлэг Эцэгийн хайранд урьдаг. Тав дахь зарлиг нь “Эцэг эхээ хүндэл. Тэгвэл чиний Бурхан Эзэний чамд өгсөн газар дээр чи урт наслах болно”¹ хэмээн урьдаг. Бид Бурханаа болон эцэг эхээ хүндэлснээр өмнөх үеийнхнийхээ уламжлал, үйл хэрэгт хүндэтгэлтэй байхын зэрэгцээ сайн мэдээний соёлыг бүтээхэд анхдагч нь байж чадна.

Бие биедээ эхнэр буюу нөхөр нь байх

Азийн бүсэд олон итгэлтэй сүмийн гишүүн нь эхнэр буюу нөхрөөсөө өмнө сүмд нэгддэг. Эдгээр бүхнээ зориулсан ах эгч нар сүмдээ итгэлтэй, түүнчлэн тэд хань ижил, гэр бүлээ хайрлаж, тэдэнд тусалж дэмждэг. Дэлхий даяарх санваарын удирдагчдын сургалт² эцгүүд болон санваартан ах нарын эн тэргүүнд тавих зүйлс нь: нэгдүгээрт, хань ижил болон гэр бүл; хоёрдугаарт, ажил (гэр бүлээ шударгаар, бүрэн дүүрнээр хангах); гуравдугаарт, сүмийн үйлчлэл; дөрөвдүгээрт, хувийн сонирхол, дуртай зүйлс байдаг гэжээ.

Бид ханьдаа болон гэр бүлийн гишүүдэдээ аль хэдийн сүмийн гишүүд болсон мэт хандвал тэдэнд сайн мэдээг хүлээн авахад нь тусалж болох юм. Хайр болон итгэл нь олон эхнэр, нөхөр, бусад гэр бүлийн гишүүдэд сайн мэдээ болон ариун сүмийг ойлгож, хүлээн авахад нь тусалсан. Зарим үед энэ нь олон жилийн дараа ч биелэх нь бий. Бидний гэр бүлийн нөхцөл байдал ямар ч байсан, сайн мэдээ бидэнд сайхан сэтгэлтэй, баяр хөөртэй, хүндэтгэлтэй мөн сэтгэл санаагаар бие биеэ дэмждэг байхыг заадаг.

Сайн мэдээ нь эхнэр болон нөхрүүд бие биедээ бүхий л замаар үнэнч, үүргээ хүлээсэн байхыг заадаг. Сэтгэл зүрх, оюун ухаанаараа

ханьдаа үнэнч байх нь үүнд орно. Гэр бүлийн харилцаагаа бэхжүүлэх хамгийн сайн аргуудын нэг нь өөрийн ханьдаа үйлдэл болон бодлоороо итгэлтэй, үнэнч байх юм. Тэгвэл бидний хүүхдүүд эцэг эхийнхээ чин сэтгэлийн хайр болон нөлөөлөлд аюулгүй, амар тайвныг мэдэрч чадна.

Аврагчийн Цагаатгал ба сайн мэдээ нь биднийг илүү сайн хүн болоход тусалдаг. Хэрэв бид хальтрах юм бол эсвэл зүгээр л илүү сайныг хийж сайжрахыг хүсвэл Аврагчийн хайр болон Цагаатгал бидэнд тусалж чадна. Зүрх сэтгэл, хайр, нөлөөлөл маань зөвхөн хань ижил, гэр бүл дээрээ л суурилсан байвал бидний гэр бүлтэйгээ харьцах харилцаа илүү дотно, илүү гайхалтай болох болно.

Өдөр тутам сайн мэдээгээр амьдрах нь бидний бие биеэ хайрлах болон уучлах чадвар, хүслийг нэмэгдүүлдэг. Бид бие биедээ үйлчилж, золиослол хийж мөн талархах үед гэр бүл маань илүү дотно болдог. Бид даруу байж, нэг нэгэндээ сайхан сэтгэлээр хандвал гэр бүлийнхэн маань илүү даруу, илүү сайхан сэтгэлтэй болно. Энэ амьдралд болон үүрд мөнхөд бидэнд байж болох хамгийн агуу адислаалуудын нэг нь гэр бүлийн нэгэн гишүүн байх юм. Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээгээр дамжуулан бид гэр бүлийнхээ харилцааг бэхжүүлэхэд тусалж чадах зарчмууд, зарлигууд мөн гэрээнүүдийг хүлээн авдаг. Энэ нь гэр бүлийн харилцааг өдөр бүр бэхжүүлж, мөнх амьдрал руу хүргэж чадна.

Бид гэр бүлийн гишүүн бүрээ, нөхрүүдээ эсвэл эхнэрүүдээ, үе үеийн гэр бүлийн гишүүдээ хайрлаж, урамшуулж, дэмжиж мөн хүндлэх болно хэмээн би залбирч байна. Ингэснээр Тэнгэрлэг Эцэг биднийг илүү дотно мөн гайхалтай гэр бүлийн харилцаагаар адисална хэмээн би залбирч байна. Есүс Христийн нэрээр, амен. ■

NOTE

1. Египетээс гарсан нь 20:12.
2. Ахлагч Күингтин А.Күүк *Selected Principles from the New Handbooks*, 2010; Дэлхий даяарх удирдагчдын сургалт, 2010, lds.org.

Орон нутгийн хэвлэл мэдээллийн албаны гишүүн Э.Мөнх-Оргил

Сүм өсвөр үеийнхэн болон залуу насанд хүрэгчдийн дунд хамтдаа сайн мэдээнд өсөн хөгжиж, бие биенээсээ суралцан, үйлчлэл болон нөхөрлөлийг бий болгох үйл ажиллагаануудыг урамшуулан дэмждэг билээ. Ийм үйл ажиллагаануудаар дамжуулан залуучууд бие биенээ танин мэдэж, мөнхийн хамтрагчаа олох бодит боломжийг олгодог. Зүүн дүүргийн залуучууд энэ оны 3-р сарын 30-ны өдөр дүүрэг болон гадасны залуучуудыг оролцуулан “Бүжиг ба болзоо” сэдэвт үйл ажиллагааг амжилттай зохион байгууллаа. Танхим дүүрэн залуус хөгжмийн эгшигт хөл нийлүүлэн бүжиглэж, цагийг хөгжилтэй мөн зохистой өнгөрүүлээ. ■

Монгол дахь Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Түүхээс

А.Тунгалаг

Улаанбаатар Баруун Гадасны түүхч

2009.01.11. “Гэр бүлийн түүх” сэдэвт галын дэргэдэх ярилцлага болж, УБ Номлолын Ерөнхийлөгч Д.Аллэн Андэрсэн ах тэргүүлж, дүүргийн ерөнхийлөгчийн зөвлөлийн 1-р зөвлөх Н.Адъяаболд ах хөтлөв.

2009.02.17. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Рассэл М.Нэлсон ах Монголд айлчилж, Монголын гэгээнтнүүд амьд төлөөлөгчийн үгийг сонсов.

2009.03.14. Сүмийн НХБүлгийн 167 жилийн ойн баярыг тэмдэглэв.

2009.04.25. Улаанбаатар дүүргийн гэгээнтнүүдийн санаачилгаар байгаль орчноо цэвэр байлгах үйл ажиллагаанд Монгол дахь шашны зарим бүлгүүд “Мормон тусламжийн гар” үйлчлэлд нэгдэн Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэр дэх Сэлбэ голын хөндийн хог хаягдлыг цэвэрлэх үйлчлэлд нийт 800 гаруй хүн оролцжээ.

2009.06.07. Ерөнхий Эрх Мэдэлтэн Далын Ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн Ахлагч Дональд А.Холлстром ах Монголын Улаанбаатар Баруун гадас зохион байгуулагдсаныг зарлалаа. Энэ үйл явдлыг гэрчлэхээр нийт 1200 гаруй Сүмийн гишүүд Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Соёлын Төв ордонд хуран цугларав. Монголын

Улаанбаатар дүүрэг шинэ зохион байгуулалтанд орж, Монголын Улаанбаатар Баруун Гадас, Монголын Улаанбаатар Зүүн Дүүрэг болон хуваагдаж, шинэ Гадасны Ерөнхийлөгчийн зөвлөл болон зургаан тойргийн бишопыг дуудан дэмжүүлсэн байна.

Гадасны Ерөнхийлөгчөөр О.Одгэрэл, 1-р зөвлөх Н.Адъяаболд, 2-р зөвлөх А.Цог мөн Улаанбаатар Зүүн Дүүргийн Ерөнхийлөгчөөр С.Цэрэнням, 1-р зөвлөх Б.Батзоригт, 2-р зөвлөх Д.Энхбаяр нар дуудагдав. Мөн энэ үед Гадасны Дээд санваарын зөвлөлийн гишүүд дуудагдсан онцгой үйл явдал боллоо.

2009.06.23-26. Монголын Баруун Гадас ба Зүүн Дүүргийн Залуу Эрэгтэйчүүд, Залуу Эмэгтэйчүүд чуулганаа чуулав. Эрдэнэт хотын ойролцоо “Янзага” зусланд зохион байгуулсан чуулганд 14-17 насны 300 гаруй залуу үеийнхэн 1Тимотын 4:12 шүлэг “Хэн ч чамайг залуу хүн хэмээн дорд бүү үзэг. Харин чи итгэгч хүмүүст үг, зан байдал, хайр, итгэл хийгээд цэвэр ариун байдалаараа үлгэр дууриал бол” хэмээх судрыг уриагаа болгон, дөрвөн өдөр найзлан нөхөрлөж, сүнслэг сургалтуудад оролцож мөн хамтдаа цагийг хөгжилтэй өнгөрүүлэв.

2009.07.16-18. ХҮТэгээнтэн ганц бие насанд хүрэгчдийн анхны чуулган болж, 18-30 насны 370 залуучууд оролцов. Чуулганы уриа нь: Дуулал 23:3-4 “Эзэний уул өөд хэн авирч болох вэ? Түүний ариун газарт хэн зогсож чадах вэ? Цэвэр гартай, ариун зүрхтэй, хуурмаг байдалд сэтгэлээ өргөөгүй, худал тангараг тавиагүй хүн тэгэх юм” гэсэн судар байлаа.

2009.08.14-16. Хонг Конгийн Ариун Сүмийн Ерөнхийлөгч Чарльз В.Х.Гүү,

гэргий Гүүгийн хамт айлчлав. Монгол Улсад Ариун Сүм баригдахын тулд гишүүд 50,000 ариун сүмийн ажилд илгээх нэрс цуглуулж, гэр бүлийн түүхийн санд оруулах хэрэгтэйг зөвлөжээ.

2009.08.20. ХҮТСүмийн ивээн тэтгэсэн Монголын Пара Хөнгөн Атлетикийн 2009 оны Улсын Аварга шалгаруулах тэмцэнийг Монголын Пара Хөнгөн Атлетикийн Холбоотой хамтран зохион байгуулж “Мормон тусламжийн гар”-ын онцгой үйлчлэл үзүүлжээ. Тэмцээнд 19 аймаг, хотын 18-45 насны нийт 250 гаруй хөгжлийн бэрхшээлтэй хөнгөн атлетикийн тамирчид оролцож спортын амжилт гаргахын зэрэгцээ Их Эзэний гарыг илүүтэй мэдэрсэн байна.

2009.09 сар. Сүмд анхны өглөөний семинарын хөтөлбөр амжилттай хэрэгжиж өглөөний 6:30-аас эхлэн хичээллэж, 150 гаруй өсвөр үеийнхэн хамрагдсан байна.

2009.09.29. Дезерет Олон Улсын Энэрлийн Байгууллагын тусламжийн гар үргэлжилсээр дахин 750 ширхэг тэргэнцэр хандивласанд Монголын Улаан Загалмайн Нийгэмлэг хамтран ажиллав.

2009.10.17-18. Монголын Улаанбаатар Баруун Гадас анхны чуулганаа чууллаа.

2009 он. Гишүүдийн хөдөлмөр эрхлэлтэд туслах Ажил Эрхлэлтийн алба үйл ажиллагаагаар амжилттай явуулаад эдүгээ долоон жил болж байна. Бригам Янгийн Их Сургуулийн тусламжтайгаар “Бизнесийн төв” хэмээх шинэ байгууллагыг эргэж ирсэн номлогчдод зориулан зохион байгуулж, анхны “Бизнес төлөвлөгөө бичих” тэмцээн

амжилттай явагдсан байна. Энэ нь үргэлжлэн жил бүр зохион байгуулагдсаар ирлээ.

2010.01.01. Эргэж ирсэн номлогчдын “Цэнгээнт бүжиг” гурав дахь удаагаа боллоо. Цэнгүүнд 160 гаруй залуус хүрэлцэн ирж, өөрсдийн номлолын туршлагаасаа дурсан хуваалцаж уянгалаг хөгжмийн аяар хөл нийлүүлэн бүжиглэх нь үнэхээр гайхалтай байдаг.

2010.01.03. Улаанбаатар Баруун Гадас, Зүүн Дүүргийн Найрал дууны сургалт нээлтээ хийлээ.

2010.01.04. 18-30 насны насны ганц бие насанд хүрэгчдийн Гэр бүлийн цуглаан нээлтээ хийлээ.

2010.01.05. Сүмийн хэмжээнд институт семинар амжилттай явагдаж байгаа бөгөөд 18-30 насны, 31-с дээш насны гишүүдийн институтын ангиуд дээр нэмэгдэн, эргэж ирсэн номлогчдоод зориулсан анги сургалтаа эхэллээ.

2010.01.06. Булган аймгийн төв Булган хотноо ЕХХҮГСүмийн анхны бүрэн цагийн номлогч Ахлагч Ууганбаатар, Ахлагч Хофман нар Христийн сайн мэдээг тунхаглахаар хүрэлцэн иржээ.

2010.01.07. Улаанбаатар Баруун Гадасны Зөвлөлийн Сургалт эхэллээ.

2010.01.24. Булган аймгийн Булган хотод анхны ариун ёслолын цуглаан болж, 27 хүн оролцсон байна.

2010.02 сар. Байгалийн гамшигт өртсөн аймгийн малчдад туслах хүмүүнлэгийн

тусламж Монгол орон даяар өрнөж иргэд, байгууллагууд нэгдэн толгой шүдэнз, нэмнээнээс эхлэн санхүүгийн тусламжийг харамгүй илгээсэн үйлчлэлд Сүмийн тойрог, салбаруудын гишүүд болон Дезерет ОУЭБайгууллага мөн идэвхтэй оролцож 70 гаруй сая төгрөгийн тусламж үзүүлсэн нь Булган, Сэлэнгэ, Хөвсгөл, Орхон аймгууд дахь сургуулийн 3400 гаруй сурагчийн хичээлийн танхим, дотуур байрны халаалтын системийг сайжруулах төслийг санхүүжүүлж, Ховд, Увс, Завхан аймгийн малчдад хоол хүнс, дулаан хувцас, түлш зэрэг шаардлагатай эд зүйлс нийлүүлсэн байна. Улаанбаатар Баруун Гадас, Зүүн Дүүргийн НХаламж болон Залуу Эмэгтэйчүүд нийт 500 гаруй бог, бод малын нэмнээ оёж, мөн дулаан бээлий, нэхий хөнжил хандивлажээ.

2010.03.06. Шинэ гишүүдийн Институтын хичээлийн нээлт болов.

2010. 03.13. УБ Баруун Гадасны Нийгмийн Халамжийн Ерөнхийлөгчийн зөвлөлөөс Нийгмийн Халамжийн 168 жилийн ойн баярт зориулсан “Ариун Сүм” сэдэвт үйл ажиллагаа явуулав.

2010.03.20. Булганы анхны Сүмийн гишүүд болох Б.Булганчимэг, Б.Саранчимэг, Н.Одончимэг нар Эрдэнэт хотноо баптисм хүртсэн байна.

2010.04.17. “Тэнгэрлэг Эцэгээ магтан дууля” найрал дууны фестиваль Монгол Улсын хэмжээнд анх удаа зохиогдож УБ Баруун Гадас, УБ Зүүн дүүрэг, Дархан дүүргийн 18 найрал дууны багийн 700 гаруй гэгээнтнүүд оролцлоо.

2010.05.15-16. УБ Баруун Гадасны чуулганыг Азийн Бүсийн Ерөнхийлөгч Ахлагч Антони Д.Пэркинс тэргүүлэв.

2010.05.23. Бууж буй номлогчдын галын дэргэдэх ярилцлага зохион байгуулав.

2010.05.29. СБС-ийн шашны институт семинарын төгсөлтийн галын дэргэдэх ярилцлага болов. Энэ жилийн сургалтанд 200 гаруй гишүүд, сонирхогчид хамрагдаж, шашны 4 жилийн сургалт дүүргэсэн гишүүдэд төгсөлтийн гэрчилгээ гардуулав.

2010.06.12-19. УБ Номлолын анхны Ерөнхийлөгч Ахлагч Ричард И.Күүк ба Залуу Эмэгтэйчүүдийн Ерөнхий Ерөнхийлөгчийн 1-р зөвлөх Мэри Н.Күүк эгч Монголд айлчилж олон сүнслэг сургалт болоод галын дэргэдэх ярилцлага зохион байгуулагдав.

2010.06.26. Номлолоос бууж буй УБ Номлолын Ерөнхийлөгч Ахлагч Д.Аллэн Андэрсэн, Систер Жилл Андэрсэн нарыг үдэх уулзалт Баянзүрх байранд болов.

2010.06.27. Бууж буй номлогчид, шинээр номлолд гарч буй номлогчдын галын дэргэдэх ярилцлага боллоо.

2010.07.22-24. 18-30 насны Залуу насанд хүрэгчдийн чуулган чуулав.

2010. 09 сар. Азийн Бүсийн Ерөнхийлөгчийн зөвлөлийн 2-р зөвлөх Ахлагч Карл Б.Пратт болон Азийн Бүсийн Далын гишүүн Ахлагч Стэнли Вон нар айлчлан ирэв.

2010.09.05 Ерөнхий Эрх Мэдэлтнүүдийн галын дэргэдэх ярилцлагаар Азийн Бүсийн Ерөнхийлөгчийн 2-р зөвлөх Ахлагч Карл Б.Пратт, Азийн Бүсийн Ерөнхийлөгчийн Зөвлөлийн гишүүн Ахлагч Стэнли Вон нар Сүмийн түүхээс хуваалцав.

2010.10.06. Номлолд гарч буй номлогчдын галын дэргэдэх ярилцлага боллоо.

2010.10.30. Эргэж ирсэн номлогчдын “Бизнес төлөвлөгөө” тэмцээнд эргэж ирсэн номлогчид амжилттай оролцов.

2010.11 сар. Улаанбаатар Номлолын Ерөнхийлөгч Ахлагч Микам ах Систер Стефани Микам нар эрүүл мэндийн шалтгаанаар дуудлагаасаа чөлөөлөгдөж, Ерөнхийлөгч Кларк ах, Систер Патриша Хоже Кларк нар дуудагдсан байна.

2010.11.06-07. Улаанбаатар Баруун Гадасны чуулган боллоо.

2010.11.21. Бууж буй номлогчдын галын дэргэдэх ярилцлага болов.

2010.11.27. Улаанбаатар Баруун Гадасны зургаан Тойрог, Улаанбаатар Зүүн Дүүргийн дөрвөн Салбарын хамтарсан ХҮГ-ийн Найрал дууны наадам хоёр дахь жилдээ 355 оролцогчтойгоор зохион явагдлаа. Тоглолтыг 700 гаруй гишүүд, сонирхогчид үзжээ.

2010.12.04. 18-30 насны ганц бие залуучуудын онцгой үйл ажиллагаа явагдав.

2010.12.25. Христийн мэндэлсний баярын “Тэнгэрлэг Эцэгээ магтан дуулья” хөгжимт галын дэргэдэх ярилцлага боллоо. ■

Бурханд үйлчлэхээр дуудагдлаа 2012 оны 8 ба 11-р сараас эхлэн үйлчилж буй номлогчид



Майдарын Дариймаа,
Сансар тойрог, 2012
оны 8-р сар



**Далайчулууны Лхаг-
важав,** Сансар тойрог,
2012 оны 11-р сар



**Майдарын Мөнгөн-
туяа,** Ховд салбар,
2012 оны 11-р сар



**Галбадрахын Мөнх-
зул,** Энхтайван той-
рог, 2012 оны 11-р сар



Баттөрийн Нансалмаа,
Эрдэнэт 1 салбар,
2012 оны 11-р сар



**Бат-Очирын Наранга-
равуу,** Баянзүрх сал-
бар, 2012 оны 11-р сар



**Ганзоригийн Наран-
туяа,** Сэлбэ тойрог,
2012 оны 11-р сар



Далайхүүгийн Онон,
Сансар тойрог, 2012
оны 11-р сар



**Ахлагч Цэнгэлийн
Анар,** Хайлааст сал-
бар, 2012 оны 8-р сар



**Ахлагч Баярмагнай-
гийн Осоржамаа,**
Энхтайван тойрог,
2012 оны 8-р сар



**Ахлагч Мөнхжар-
галын Мөнхчөдөр,**
Чойбалсан салбар,
2012 оны 8-р сар



**Ахлагч Энхболдын
Тулга,** Сонгино той-
рог, 2012 оны 8-р сар



**Ахлагч Өлзийдүү-
рэнгийн Ганбаатар,**
Сансар тойрог, 2012
оны 8-р сар



**Ахлагч Сольбатын
Ганзориг,** Сансар той-
рог, 2012 оны 8-р сар



**Ахлагч Хурцбаатарын
Ганшагай,** Баянзүрх
салбар, 2012 оны
11-р сар